



“ВЕЙР МИНЕРАЛС МОНГОЛИА” ХХК  
ЗАХИАЛАГЧ



“ЦАГААН УУЛЫН ОРГИЛ” ХХК  
ГҮЙЦЭТГЭГЧ

# 2023

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ, 20-Р ХОРОО

“МЕТАЛЛ ХИЙЦИЙГ РЕЗИНЭН ХУЯГААР ДОТОРЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВД  
АШИГЛАГДАХ ХИМИЙН БОДИСЫГ ИМПОРТЛОХ, АШИГЛАХ, ХАДГАЛАХ,  
ХУДАЛДАХ” ТӨСӨЛ (НЭМЭЛТ ТОДОТГОЛ)

УЛААНБААТАР ХОТ  
2022 он

**2023 ОНЫ  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

1. Төслийн товч танилцуулга
2. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
3. 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

## НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

### 1.1. Төслийн товч тодорхойлолт

Төслийн нэр:	“Металл хийцийг резинэн хуягаар доторлох үйлчилгээний төвд ашиглагдах химиин бодисыг импортлох, ашиглах, хадгалах, худалдах” төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Вейрминералс Монголиа” ХХК
Регистрийн дугаар:	5628083
Улсын бүртгэлийн дугаар:	9019065008
Холбоо барих утас:	70124297, 99238842
Төслийн ач холбогдол:	Үул уурхайн баяжуулах үйлдвэрийн шугам хоолойг тусгай аргаар боловсруулсан Линатекс брэндийн резинээр хуяглан засвар үйлчилгээ хийснээр шугам хоолойн элэгдэлтийг богиносгох, насжилтыг уртасгах, зардлыг 50 хүртэл хувиар хэмнэх ач холбогдолтой
Хүчин чадал:	Жилд 1200м <sup>2</sup> талбай бүхий шугам хоолойг хуяглаж, засвар үйлчилгээний ажил хийх хүчин чадалтай
Түүхий эд:	Линатекс брэндийн резин, 16 төрлийн цавуу, түрхлэг
Төслийн байршил:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Эрчим хүчний гудамж, 52-1 тоот
Талбайн хэмжээ:	1160м <sup>2</sup>
Ажиллах хоног:	Жилийн турш тасралтгүй.
Ажиллах хүч:	Нийт 21 ажилтантай
Үс хангамж:	Төвийн шугам сүлжээнд холбогдсон.
Бохирын шийдэл:	
Цахилгаан хангамж:	
Дулаан хангамж:	
Хог хаягдал:	Энгийн хог хаягдлын БГД-ын ТҮК, Аюултай хог хаягдлын “Түмэн эгшиг” ХХК, Шингэн хаягдлын УСҮГ-тай тус тус гэрээтэй.

### 1.1.1. Төсөл хэрэгжих орчин

Төсөл хэрэгжүүлэгч нь Баянгол дүүрэг (БГД)-ийн 20-р хороо, Эрчим хүчний гудамжид байрлах “Коммод” ХХК-ийн 1440 м<sup>2</sup> талбайтай үйлчилгээний байр, түүний баригдсан 1160 м<sup>2</sup> талбайтай газрын хамт гэрээний дагуу 2018 оноос түрээслэн үйл ажиллагаагаа явуулж байна. (Гэрээг хавсаргав.)

Төслийн талбайн баруун болон хойд талд ижил төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг “Коммод” ХХК-ийн уул уурхайн тоног төхөөрөмж засвар үйлчилгээний цех болон сэлбэг, хэрэгслийн агуулах байрладаг. Урд талд нь бараа, бүтээгдэхүүний импортын компани, зүүн талд нь “Жаст” ШТС байрлалтай. Төв замаас баруун тийш 100 м орчим зайдай.



Зураг 1. Төслийн байршил (Эх сурвалж: Google Earth)





Үрд тал



Автозогсоол



Харуулын байр



Оффис

### Зураг 2. Төслийн талбайн орчны зураг

Засвар, үйлчилгээний төв: Байгууламж нь чингэлэгэн металл рам бүхий галд тэсвэртэй, ус чийг нэвтрүүлэх болон зэврэлт үүсгэхгүй, галын аюул, халалтаас хамгаалсан мартериалаар тохижилт хийгдсэн, байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй, агаар сэлгэх салхивчтай, хаалга нь төмөр хамгаалалттай, цементэн бетон шалтай, 24 цагийн харуул хамгаалалттай.



Зураг 3. Засвар үйлчилгээний төв



Зураг 4. Засвар үйлчилгээний төвийн дотоод орчин


**2.1.2. Ажиллах хүчин:** Металл хийцийг резинэн хуягаар доторлох шугамын ажилчин, засвар үйлчилгээ хариуцсан гадаад мэргэжилтэн, менежер, санхүүгийн ажилтан болон захирал зэрэг нийт 21 ажилтантай үйл ажиллагаа явуулж байна. Засвар үйлчилгээний хэсэг 1 ээлжтэй, өдрийн 8 цагаар, ажлын 5 хоног ажилладаг.

Хүснэгт 1. Хүний нөөц

№	Салбар	Албан тушаал	Орон тоо, ш
1	Үдирдлага	Захирал	1
2		Санхүүгийн менежер	1
3		Үйлчилгээ хариуцсан менежер	1
4	Засварын төв	ХАБЭА	1
6		Резин доторлогоо цехийн ахлагч	1
7		Резин доторлогооны ахлагч	1
8		Резин доторлогоочин	5
9		Механик слесарь	2
10		Үйлчилгээ, харилцааны ажилтан	1
11	Ложистик/борлуулалт	Логижтикийн зохицуулагч/экспедитор	1
12		Санхүүгийн ажилтан	1
13		Нягтлан бодогч	1
14		Худалдааны зөвлөх	1
15		Жолооч	1
16	Инженер	Механик дизайны инженер	1
17		Нэгдлийн шийдлийн инженер	1
		Нийт	21

**1.2. Төслийн технологи:** Тус засварын төвд шугам хоолой, металл хийцийг 2 янзын технологи аргаар хуягладаг. Засвар үйлчилгээний технологийг дараах схемээр харуулав.


### 1. Гараар хуяглаж технологи



Зураг 5. Гараар хуяглаж технологийн схем

## 2. Халуун аргаар боловсруулах технологи

Энэхүү технологит агаарын хөргөлтийг ашигласан нь усны нөөцийг хэмнэх давуу талтай. Процессийг автоматаар удирдах ба бүх хэсэгт температур, даралт, зарцуулалтыг хянах удирдлагын систем, эксперийн болон сургалтын программ, аваарын хамгаалалттай.



Зураг 6. Халуун аргаар боловсруулах технологийн схем



Зураг 7. Металл хийцийн резин (Эцсийн бүтээгдэхүүн)

**1.3. Тоног төхөөрөмж:** Технологийн үйл ажиллагаанд уурын бойлер, ус зөөлрүүлэгч, автоклав, өргөх, бүүлгах, зүсэх тоног төхөөрөмж, зүлгүүрийн багаж хэрэгслүүдийг ашиглана.



Зураг 8. Тоног төхөөрөмж

Уурын бойлер одоогоор ажиллагаагүй.

#### 1.4. Түүхий эд, материал

Төслийн үйл ажиллагаанд ашиглах туслах материалууд болох барьцалдуулагч цавуу, хурдан хатаагч бодис, металлыг зэврэлтээс хамгаалагч, резин дүүргэгч, шингэлэгч, угаагч зэрэг 16 төрлийн жилд 47.3 тн химийн бодисуудыг толгой компаниас импортоор авч ашиглана. Бодисуудын талаарх мэдээллийг дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 2. Химийн бодисуудын талаарх мэдээлэл

№	Бодисын нэр	Олон улсын нэршил	Химийн томъёо	CAS дугаар	Импортын хэмжээ (жилээр)	Савлагаа, төлөв
1	Солюфикс 30A	Solufix 30A	$\text{CH}_3\text{COOC}_2\text{H}_5$	141-78-6	500ш (1250 л)	2.5 л лааз
2	Солюфикс 30B	Solufix 30B	$\text{C}_3\text{Cl}_3\text{N}_3\text{O}_3$ $\text{C}_3\text{Cl}_2\text{N}_3\text{NaO}_3$ * $2\text{H}_2\text{O}$	87-90-1 51580-86-0	350ш (17.5 кг)	50 гр хуванцар
3	Солюфикс 14B	Solufix 14B	$\text{CH}_3\text{COOC}_2\text{H}_5$ $\text{C}_6\text{H}_3(\text{NCO})\text{CH}_2-$ $\text{C}_{15}\text{H}_{10}\text{N}_2\text{O}_2$	141-78-6 9016-87-9	350ш (262.5 кг)	750 гр лааз
4	Солюфикс 14T	Solufix 14T	$\text{C}_6\text{H}_5\text{CH}_3$ $\text{C}_2\text{H}_5\text{COCH}_3$ $\text{CH}_2\text{CH}=\text{C}(\text{Cl})\text{CH}_2$	108-88-3 78-93-3 9010-98-4	650ш (2600 л)	4 л лааз
5	Лорд Химлок 205	Lord Chemlock 205	$\text{C}_4\text{H}_8\text{O}$ $\text{C}_6\text{H}_4(\text{CH}_3)_2\text{TiO}_2$	78-93-3 1330-20-7 13463-67-7	150ш (600 л)	
6	Толуол	Toluene	$\text{C}_6\text{H}_5\text{CH}_3$	108-88-3	400ш (400 л)	1 л шилэн сав
7	Вир рапид стоп	WearStop Rap- id Part A	$(\text{CH}_3)_2\text{C}(\text{C}_6\text{H}_4\text{OH})_2$ $(\text{NH}_2\text{CH}_2\text{CH}_2)_2\text{NH}$	80-05-7 111-40-0	100ш (700 кг)	7 кг хуванцар
8	Вир рапид стоп	WearStop Rap- id Part B	$(\text{CH}_3)_2\text{C}(\text{C}_6\text{H}_4\text{OH})_2$	80-05-7	100ш (700 кг)	
9	ELI-флекс	ELI- FLEX	$\text{C}_9\text{H}_{18}\text{Cl}_3\text{O}_4\text{P}$	69102-90-5 13674-84-5	150ш (150 кг)	1 кг гялгар уут
10	Локтит СФ	LOCTITE SF 7467	-	-	1000ш (5000 л)	5 л хуванцар
11	Лина 885 А	Lina 885 А	$\text{Cl}_2$	7782-50-5	1750ш (7880 кг)	4.5 кг хуванцар
12	Лина 888 В	Lina 888 В	$\text{C}_6\text{H}_3(\text{NCO})\text{CH}_2$	101-68-8 9016-87-9 5873-54-1 4083-64-1 2336-05-2	350ш (3500 кг)	10 кг хуванцар
13	Лина 888А	Lina 888 А	$\text{C}_{21}\text{H}_{30}\text{N}_2$ $\text{C}_{12}\text{H}_{31}\text{NO}_6\text{Si}_2$	5285-60-9 82985-35-1	700ш (11900 кг)	17 кг хуванцар
14	Лина 885 В	Lina 885 В	$\text{HKO}_6\text{S}$	70693-62-8	1900ш (8600 кг)	4.5 кг хуванцар
15	Солюфикс 14TAS	Solufix 14TAS	$\text{C}_6\text{H}_{12}$ $\text{C}_4\text{H}_8\text{O}_2$	110-82-7 141-78-6	650ш (2600 л)	4 л лааз
16	Солюфикс 10T	Solufix 10T	$\text{C}_7\text{H}_8$ $\text{C}_6\text{H}_5\text{CH}_3\text{C}$	109-88-3 1333-86-4	300ш (1200 л)	
Нийт					47360кг	-

Эдгээр бодисууд нь Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт", Олон улсын гэрээ конвенцид хамрагдсан байдлаар Удаан задардаг органик бохирдуулагчдын тухай "Стокгольмын конвенци", Зарим аюултай химийн бодис, пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх

урьдчилан мэдээлж, зөвшилцөх журмын тухай “Роттердамын конвенци”, Озоны үе давхаргыг хамгаалах тухай “Венийн конвенци”-ийн хориглосон, хязгаарласан заалтад тус тус хамаарахгүй.

Бодисуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн 6 дугаар бүлэг “Эрсдэлийн үнэлгээ” хэсэгт тусгав.

**Химийн бодисын хадгалалт:** Төсөлд ашиглагдах химийн бодисууд нь харьцангуй бага хэмжээгээр савлагдсан байдаг бөгөөд засварын төвд ашиглагдах хэмжээгээр дотор байрлах байрлах шүүгээнд хэсэгчлэн авч хадгалдаг.

Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн 2019 оны 01-04-063/106 дугаар Агуулах, ажлын байрны тухай дүгнэлттэй.

Дүгнэлтээр агуулах, ажлын байр нь “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 10 дугаар зүйлд заасан химийн бодис хадгалахад тавигдах үндсэн шаардлага болоод “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын 3.2.1.6-д заасан шаардлага, “Химийн хорт болон аюултай бодис, бүтээгдэхүүний агуулах. Ерөнхий шаардлага” MNS 6458:2014 стандартад нийцэж байна.



Зураг 9. Химийн бодисын гаднах агуулах


Үйлчилгээний төвд байрлах хэсэгчлэн хадгалах шүүгээнүүд нь химийн бодисыг монгол нэр, олон улсын нэршил, томьёо, GAS дугаар, тоо хэмжээг бүртгэсэн, эрүүл мэндэд нөлөөлөх, гал авалцах, урвалд орох зэрэглэл зэрэг үзүүлэлтүүдээр нь ангилан хадгалсан, химийн бодистой харьцан ажиллах аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулан ашиглалтын явцад мөрддөг, аюулгүй ажиллагааны дохио, санамж тэмдэглэгээнүүдийг хийж байрлуулсан, шаардлагатай үед хэрэглэх нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, гар болон нүд угаах төхөөрөмжөөр бүрэн хангагдсан.



Зураг 10. Ажлын байран дахь химийн бодис түр хадгалах хайрцаг

### 1.5. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа

Ажилчдын хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудлыг нэн тэргүүнд тавьж осол, эрсдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлэн цаашид OHSAS 18001:2007 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны удирдлагын тогтолцоо” олон улсын стандартыг хэрэгжүүлэн ажиллахаас гадна байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг аль болох бага байлгах талаар санаачлагатай ажиллаж байна.



Зураг 11. Ажлын байранд аюулгүй ажиллагаа, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл байрлуулсан байдал

## 1.6. Ус хангамж

Хэрэглээний усыг цэвэр бохир усны төвлөрсөн шугам сүлжээнээс түрээслэгч байгууллага болох “Коммод” ХХК, Ус сувгийн удирдах газар(УСҮГ)-ын хооронд 2017 онд байгуулсан “Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлцуулах” (баталгаажсан тоолууртай) гэрээний дагуу авч ашигладаг. Гэрээг хавсаргав.

УСҮГ, Түрээслэгч байгууллагын сүүлийн саруудын тооцооны хуудас, төсөл хэрэгжүүлэгчийн усны төлбөр төлсөн баримтуудыг үндэслэн төслийн сарын усны хэрэглээг дараах байдлаар тооцов. Тооцоогоор төсөл нь сард дунджаар  $47.2 \text{ m}^3$ , хоногт  $2.1 \text{ m}^3$  ус ашигладаг тооцоотой. УСҮГ-ын гэрээний 2.2 заалтын дагуу хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээ нь хэрэглэгчийн хэрэглсэн цэвэр усны хэмжээтэй тэнцүү хэмжээгээр тооцогдоно.

Хүснэгт 3. 2022.03-2022.06 сарын цэвэр болон бохир усны хэмжээ

Cap	Тоолуурын заалт, “Коммоп” ХХК				“Вэйр Минералс Монголиа” ХХК	
	Эхний заалт, $\text{m}^3$	Эцсийн заалт, $\text{m}^3$	Зөрүү, ашигласан усны хэмжээ, $\text{m}^3$	Усны төлбөр, мян.төг	Усны төлбөр, мян.төг	Ашигласан усны хэмжээ, $\text{m}^3$
2022.01.20-2022.02.21	-	-	-	-	118.3	65.7
2022.02.14-2022.03.14	2050	2150	100	180.0	100.5	55.8
2022.03.14-2022.04.15	2150	2227	77	138.6	77.7	43.2
2022.04.15-2022.05.13	2227	2265	38	68.4	41.9	23.3
2022.05.13-2022.06.15	2265	2315	50	90.0	86.9	48.2
Нийт	-	-	265	-	-	236.2
Дундаж	-	-	66.2	-	-	47.2

Эх сурвалж: Компанийн инженер техникийн алба, УСҮГ, 2022.03-2022.06 тооцооны хуудас, Түрээсийн төлбөрийн нэхэмжлэх(Усны төлбөр)

Дээрх 5 сард ашигласан усны хэмжээнд үндэслэн төсөл хэрэгжүүлэгчийн 2022 оны нийт ус ашиглалтын хэмжээг урьдчилсан байдлаар тооцоход сарын дундаж хэрэглээ  $47.2 \text{ m}^3$  байхад ирэх 6-12 дугаар саруудад ашиглах усны хэмжээ  $47.2 \text{ m}^3 * 6 \text{ сар} = 283.2 \text{ m}^3$  бол 2022 онд ашиглах нийт усны хэмжээ  $236.2+283.2=519.4 \text{ m}^3$  байх тооцоотой.

## 1.6. Хог хаягдлын эх үүсвэр

Төслийн үйл ажиллагааны явцад засварын төв, химийн бодисын агуулах, оффис болон ажилчдын ахуйн хэрэглээнээс жилд дунджаар нийт 8 орчим төрлийн 2.9 тн (хатуу) 519.4 м<sup>3</sup> (шингэн) хог хаягалд үүсдэг. Хог хаягдлыг эх үүсвэрээр нь ангилан доорх хүснэгтэд харуулав.

Хүснэгт 4. Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын эх үүсвэр, төрөл

№	Хог хаягдлын төрөл	Эх үүсвэр				Дахин ашиглах	Үстгах
		Засвар үйлчилгээний төв	Оффис	Химийн бодисын агуулах	Ажилчид		
Энгийн хатуу хог хаягдал							
1	Хаягалд резин	✓					
2	Мод модон эдлэл	✓					
3	Цаас, картон	✓	✓			✓	✗
4	Хуванцар		✓		✓		
5	Хаягалд маск, бээлий				✓		
6	Ахуйн холимог хог хаягдал				✓	✗	✓
7	Бусад	✓	✓				
Аюултай хог хаягдал							
8	Химийн бодисын сав баглаа боодол			✓		✗	✓
Шингэн хог хаягдал							
9	Шингэн хог хаягдал		✓		✓	✗	✓

### 1.6.1 Үүсэх хог хаягдлын хэмжээ

Хог хаягдлыг БОАЖСайдын 2017 оны А/349 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл"-ийн дагуу эх үүсвэр, төрлөөр нь ангилж кодчилох ба код нь 6 цифрээс бүрдэнэ. Эхний 2 цифр нь хог хаягдлын бүлгийг, дараагийн 2 цифр нь хог хаягдлын дэд бүлгийг, сүүлийн 2 цифр нь дэд бүлгээс үүсэх хог хаягдлын төрлүүдийг тус тус заана. "99"-өөр төгссөн кодтой "Тусгайлан заагдаагүй бусад хог хаягдал"-д тухайн дэд бүлгийн жагсаалт болон 13-16 дугаар бүлгийн жагсаалтад ороогүй бусад хог хаягдлын хамруулна.

Төслийн үйл ажиллагаанаас үүсэх энгийн хог хаягдлыг 20 дугаар бүлэгт, аюултай хог хаягдлыг 15 дугаар бүлэгт тус тус хамааруулан ангилж дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5. Хог хаягдлын бүлгийн код

Бүлгийн код	Хог хаягдлын бүлэг
20	Ахуйн хог хаягдал (түүнтэй найрлага, бүтцийн хувьд ижил үйлдвэр, үйлчилгээ, албан байгууллагын хог хаягдал)
15	Сав, баглаа боодлын хаягдал: Шингээгч, бохир алчуур, материал, фильтрийн материал, тусгайлан заагдаагүй хамгаалалтын хувцас
08	Гадаргуу бүрэгч материал(будаг, лак, паалан), цавуу, чигжээс, хэвлэлийн будаг үйлдвэрлэх, бэлтгэх, тээвэрлэх, хэрэглэх үед үүсэх хаягдал
11	Метал болон бусад материалын гадаргуугийн химийн боловсруулалт ба гадаргууг бүрэх үед үүсэх хаягдал. Өнгөт төмөрлөгийн гидрометаллургийн процессын хаягдал

Төслийн үйл ажиллагаас үүсэх энгийн хатуу хог хаягдлыг дүүргийн ТҮК болох “Баянгол Шинэ Өргөө” ОНӨААТҮГ-тай байгуулсан “Хог хаягдал тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх гэрээ”, аюултай хог хаягдлыг “Түмэн эгшиг” ХХК-тай байгуулсан “Химиин бодисын хаягдал, баглаа боодол шилжүүлэх, устгах гэрээ”, ахуй хэрэглээнээс үүсэх шингэн хаягдлыг УСҮГ-тай байгуулсан гэрээний дагуу тус тус зайлцуулж байна.

#### Хүснэгт 6. Жилд гарах нийт хог хаягдлын хэмжээ

№	Ангилал	Хог хаягдлын төрөл	Хэмжээ	Тайлбар
Энгийн хатуу хог хаягдал				
1	20 01 01	Цаас, картон	12-35кг	“Баянгол Шинэ Өргөө” ОНӨААТҮГ-тай байгуулсан гэрээний дагуу зайлцуулдаг.
2	20 01 26	Мод, модон эдлэл (поддон)	200-300кг	
3	20 01 99	Хаягдал маск, бээлий	12-18кг	
4	20 03 01	Ахуйн холимог хаягдал	1.25-1.62тн	
5	20 01 15	Резин зоргодос	0.5-1.0тн	
Аюултай хог хаягдал				
6	15 01 09	Металл сав баглаа боодол	2600 ш	“Түмэн эгшиг” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу зайлцуулдаг.
7		Хуванцар сав баглаа боодол	6250 ш	
8		Гялгар уут сав баглаа боодол	150 ш	
9	15 02 01	Хортой бодисоор бохирдсон шингээгч, алчуур, материал	-	
10		Ашигласан ажлын хувцас	-	
Шингэн хог хаягдал, м <sup>3</sup>				
11	-	Шингэн хог хаягдал	519.4*	УСҮГ-тай хийсэн гэрээний дагуу төв цэвэрлэх байгууламжид нийлүүлдэг.
Нийт			Энгийн хатуу хог хаягдал: 1.5-2.9 тн Аюултай хог хаягдал: 9000 ш Шингэн: 519.4 м <sup>3</sup>	

Эх сурвалж: Компанийн инженер техникийн алба

\* - УСҮГ-ын тооцооны хуудас, УСҮГ-ын гэрээний 2.2 заалтын дагуу хэрэглээнээс гарсан бохир усны хэмжээ нь хэрэглэгчийн хэрэглсэн цэвэр усны хэмжээтэй тэнцүү.



Зураг 12. Хог хаягдлын түр хадгалалт

## ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

### 2.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн шинжилгээ

Төсөлтэй холбоотой баримт бичиг, бүртгэл тэмдэглэл, агуулахын орчинд хийсэн орчны хяналт шинжилгээний үр дүн, төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчин төлөв байдал, бохирдол доройтлын түвшин, химиин бодисын эрсдэлийн үнэлгээний үр дүн зэрэгт үндэслэн үйлчилгээний төвийг З-н хэсэгт хуваан хэсэг тус бүрт магадлан жагсаах буюу хяналтын болон асуулгын хуудасны арга, математик статистикийн аргуудыг ашиглан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах алхмуудаар тодорхойлов.

**Алхам 1.** Төслийн гол зорилго, техник технологи, эдийн засгийн хүчин чадал, үндсэн болон туслах үйл ажиллагаанд байгаль орчны шинжилгээ хийж эхний ээлжинд анхаарах асуудлуудыг тодорхойлохын тулд нөлөөллийн байж болох эх үүсвэрүүдийг аль болох бүрэн хамруулан нөлөөлөлд өртөж болзошгүй объектууд, бүх орчныг тодорхойлсон.

Хүснэгт 7. Сөрөг нөлөөллийн эх үүсвэр (Магадлан жагсаах арга)

№	Нөлөөллийн шинжилгээ хийхэд анхаарч, авч үзэх асуудлууд	Хариулт
1	Тухайн орон нутгийн хувьд физик өөрчлөлт гарах эсэх	Үгүй
2	Усны нөөцийг ашиглах эсэх	Үгүй
3	Усны нөөцийг хомсдуулах эсэх	Үгүй
4	Байгалийн дагалдах нөөц, баялаг ашиглах эсэх	Үгүй
5	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химиин бодис, материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх эсэх	Тийм
6	Хатуу хог хаягдал үүсэх эсэх	Тийм
7	Шингэн хаягдал үүсэх эсэх	Үгүй
8	Агаарт аливаа төрлийн бохирдуулагч бодис ялгарах эсэх	Үгүй
9	Дуу чимээ, доргио чичиргээ, гэрлийн болон дулааны нөлөөлөл, цахилгаан соронзон цацраг үүсэх эсэх	Үгүй
10	Ус бохирдуулах эсэх	Үгүй
11	Хүний эрүүл мэнд, амь нас, байгаль орчинд нөлөөлөхүйц осол аваар, эрсдэл гарах эсэх	Тийм
12	Агуулахын байршил нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай зөрчилдөх эсэх	Үгүй

**Үр дүн:** Төслөөс шалтгаалан орон нутагт физик өөрчлөлт гарахгүй. Технологид ус үйл ажиллагаанд ус хэрэглэхгүй.

Үйл ажиллагааны явцад жилд нийт 3 тн орчим энгийн болон химиин бодисын сав баглаа боодлын хаягдал үүсэх тооцоотой.

Төслийг хэрэгжүүлэх явцад орон нутгийн хэтийн хөгжилд сөрөг нөлөөтэй үйл ажиллагаа (хүн амыг нүүлгэн шилжүүлэх, түүх соёлын дурсгалт газрыг гэмтээх, ой модыг огтлох, гэмтээх зэрэг) явуулахгүй, мөн төсөл хэрэгжих орчинд үйл ажиллагаа явуулж буй бусад байгууллагатай зөрчилдөхгүй.

## 2.2. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Төслийн хэвийн үйл ажиллагааны явцад хүний эрүүл мэндэд, бодис бүтээгдэхүүний хоруу чанаас байгаль орчинд шууд гол сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Үйл ажиллагааны үед резин, мод болон гялгар үүт, төмөр сав зэрэг сав, баглаа боодлын, ажилчдын ахуйн хатуу, шингэн хаягдал байгаль орчинд үүснэ.

Төслийн болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлов.

Хүснэгт 8. Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл

	Хүний эрүүл мэндэд	Байгаль орчинд
Үйл ажиллагаанаас	<ul style="list-style-type: none"><li>- Бүрэн бус тоног төхөөрөмжтэй харьцах үед болзошгүй осол, эрсдэл үүсэж хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.</li><li>- Ажиллагсдын дотоод журмын зөрчил, ажлын хариуцлага алдах зэргээс осол, эрсдэл үүсч болзошгүй.</li><li>- Байгалийн гамшигт үзэгдлийн улмаас хүний эрүүл мэнд, амь нас эрсдэж болзошгүй.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Цавуу, түрхлэгийн хадгалалт, ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа алдагдах, осол эрсдэлийн улмаас химиин бодис алдагдах замаар агаарын болон хөрсний хими, физик шинж чанаарыг өөрчлөх, бохирдуулах, байгаль орчинд тархах.</li><li>- Уурын зуухны яндангаар агаар бохирдуулах бодис ялгарч агаарт хаягдах.</li><li>- Автотээврийн хэрэгслийн тос, тосолгооны материал асгараах, алдагдах зэргээр хашааны хөрсийг бохирдуулж болзошгүй.</li></ul>
Бодис, бүтээгдэхүүний хоруу чанаас	<ul style="list-style-type: none"><li>- Сав, баглаа боодлын гэмтлийн улмаас бодис асгарч арьс, нүдтэй шууд хүрэлцвэл цочроох, харшил үзүүлж болзошгүй.</li></ul>	<ul style="list-style-type: none"><li>- Бодис, бүтээгдэхүүний сав, баглааны бүрэн бүтэн байдал алдагдсан, гэмтэний улмаас бодис асгараах, дэгдэмхий нэгдэл агаарт тархах зэргээр агаар, хөрс, улмаар гүний усны бохирдол үүсгэж болзошгүй. Эрсдэл үүссэн тохиолдолд үйлчилгээний төвийн шал нь бетонон хийцтэй учраас тархах орчин хязгаарлагдмал, хөрсөнд шууд алдагдах аюул бага.</li><li>- Химиин нэгдлүүд хөрсөнд их концентрацитай орвол хөрсний өнгөн давхарга бохирдох, хөрсний өөрийгөө цэвэршүүлэх чадвар алдагдаж, хүн амьтан, ургамалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.</li></ul>

## ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Зорилго:** Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

### Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх,
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх.

Төслийн 2022-2026 оны БОМТ-г БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаалын хавсралтаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.

Төслийн үйл ажиллагааны онцлог, байршил зэргээс шалтгаалан БОМТ-нд багтаж хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө, түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд тусгагдаагүй болно.

Энэхүү БОМТ-нд төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцсөний үндсэн дээр сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө(4), химийн бодис болон осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө(8), БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө(12), БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчад тайлагнах төлөвлөгөө(3) болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөр(4)-ийн нийт 31 ажил багтсан бөгөөд төслийн 2023 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 5.1 сая.төг зарцуулахаар төлөвлөв.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн 11 дүгээр сарын 01-ний дотор тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу хэрэгжүүлж тайлагнах, дараа оны БОМТ-г 12 дугаар сарын 31-ний дотор холбогдох байгууллагад хүргүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 9. 2023 оны БОМТ-ний зардал, сая.төг

№	Менежментийн төлөвлөгөө	Ажил, ш	2022
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	4	0.9
2	Химийн бодис болон осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	8	4.2
3	БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	12	-
4	БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчад тайлагнах төлөвлөгөө	3	Үйл ажиллагааны зардлаар
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр Нийт	4 31	- 5.1

### 3.1. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө

#### 3.1.1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 10. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил	Гарах үр дүн	Хамрах хүрээ	Хэрэгжих хугацаа, давтамж, зардал, сая.төгрөг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
				2023	
1	Эзэмшил ашиглалтад байгаа болон түүний орчны 50м хүртлэх нийтийн эзэмшлийн зам талбайд тохижилт, арчилгаа хийх	Хөрсийг бохирдооос урьдчилан сэргийлнэ	Эзэмшил газар, түүний ойр орчим	0.1	"Хөрс хамгаалах, цэлжилтөөс сэргийлэх тухай хууль"-ийн 7.2.4, НЗД-ын 2013 оны А/623 дугаар захирамж Газар эзэмшүүлэх гэрээний 4.19
2	Эзэмшил талбай дотор ил задгай хог хаягдлыг цэвэрлэх, дахин үүсгэхгүй байх			-	"Эрүүл ахуйн тухай хууль"-ийн 4.4.3, "Хог хаягдлын тухай хууль"-ийн 9.2.2, 9.4.8
3	Хатуу хог болон аюултай хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх			-	БОАЖСайдын 2018 оны А/18 дугаар тушаалын 3, 4 дүгээр хавсралт
4	Бүтээгдэхүүн хураах талбайг хатуу хучилттай болгох, зам талбайг тохижуулах		Эзэмшил газар	0.8	"Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага" MNS 5342:2007, "Явган хүний зам, талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага" MNS 6808:2019, "Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт" MNS 5914:2008, "Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах" MNS 6260:2020
Нийт зардал				0.9	-

### 3.1.2. Химиин бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 11. Химиин бодисын болзошгүй эрсдэл, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар	Хэрэгжих хугацаа, давтамж, зардал, сая.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
			2023	
Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа	Ажиллагсдыг эрүүл мэндийн хугацаат үзлэг, шинжилгээнд хамруулах	Нийт ажилтан	Гэрээний үнийн дүнгээр	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль” 14, 15-р зүйл “Худалдаа, үйлчилгээний байгууллагын ажилтныг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах журам” ЭМ-ийн сайдын 2017 оны А/145 тоот тушаал
	Хөдөлмөр хамгааллын сургалт улиралд 1 явуулах		0.2	
	Аюулгүй ажиллагааны дотоод журмын хэрэгжилтэнд хяналт тавих, мөрдүүлэх		-	
Химиин бодисын эрсдэл	Химиин бодистой харьцаж буй ажилчдад химиин бодисын хор аюул, аюулгүй ажиллагааны талаарх сургалт зохион байгуулах	Химиин бодистой харьцаж ажиллагсад, Тээвэрэлт хийж буй жолоочид	-	“Хөдөлмөр хамгаалал. Дохионы өнгө, аюулгүй ажиллагааны тэмдгүүд” MNS 0012.4.002-85 “Хөдөлмөр хамгаалал. Аюулгүй ажиллагааны тэмдэг ба дохионы өнгө” MNS 4643:1998 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 27.3.4, 28.1.8
	Химиин бодистой харьцаж ажиллагсад, Тээвэрэлт хийж буй жолоочид		-	
	Эрсдэлд өртсөн тохиолдолд эмнэлгийн анхны тусlamж үзүүлэх, ойр орчмын хүн амьг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах, өвчлөлийг бүрэн эмчлэх	Эрсдэлд өртсөн ажиллагсад	Үйл ажиллагааны зардлаар	
Болзошгүй эрсдэл тохиолдсон үед эрсдлийг бууруулах, арилгах арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрсдэлийн сан үүсгэх, байнгын бэлэн байдалд байлгах	Ноцтой ослын үед аюулын бүс тогтоох, мэргэжлийн байгууллага (ОБЕГ, МХЕГ)-д нэн даруй мэдэгдэж дүгнэлт гаргуулах, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулах	Агуулахын хэмжээнд		“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 27.3.4, 28.1.8
	Компани		4.0	
Нийт зардал			4.2	

### 3.1.3. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

#### Хүснэгт 12. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Зардал, сая.төг	Шаардлага
1. Хуулийн хэрэгжилтийг хангуулах				
1	БОМТ-д тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан ўйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	Төслийн нийт хугацаанд	Дотоод зардал	"Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 31 дүгээр зүйл
2	Экологийн паспорт хөтлөх			"Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 31.3 заалт, "Байгаль орчны хамгаалал. Аж ахуй нэгжийн э к о л о г и й н паспорт. Үндсэн дүрэм" MNS 4219:1994
3	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг зохих хугацаанд нь хийж гүйцэтгэх ба биенэлтийг жил бүр дүгнэж, дүнг байгаль орчны хяналтын байгууллагад хүргүүлж байх	Жил бүрийн 11-р сарын 1-ээс өмнө	-	"Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль"-ийн 14.1.2 заалт
4	Байгаль орчныг хамгаалахад дүүргийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг жил бүр зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах	Жил бүрийн 6-р сард	-	БОАЖСайдын 2018 оны А-429/257 тоот тушаалын хавсралт, Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, 2017
5	Эрх бүхий байгууллагаар баталгаажсан усны тоолуур суурилуулах	2023 он	Үйл ажиллагааны зардлаар	БОНХСайдын 2013 оны А/156 дугаар тушаалын хавсралт, "Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам" 1.3, 2, 3.6
6	Хаягдал усны дүгнэлт гаргуулж, ус бохирдуулсны төлбөр төлөх	Жил бүр		"Усны тухай хууль"-ийн 24.2, 24.5, 25.1 заалт, "Төсвийн тухай хууль"-ийн 23.6.5 заалт
7	БОННҮ тайланг үндэслэн ЗГХА, "Усны газар"-т хандан Усны ашиглах боломжит нөөцийн дүгнэлтийг 5 жилд 1 удаа, Ус ашиглуулах дүгнэлтийг жил бүр гаргуулж байх	2023 он		"Усны тухай хууль"-ийн 16 <sup>1</sup> .4.10, 28.4 заалт

2. Ажиллагсдыг чадавхижуулах				
8	Ажилчдыг хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтанд тогтмол хамруулах, чадавхижуулах	Жил бүр	Эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардлаар	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль”-ийн 27.3.4, 28.1.8-р заалт “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль”-ийн 13.6
9	Онцгой байдлын хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулж, гэнэтийн осол, эрсдэл, түүнээс хамгаалах талаар сургалт зохион байгуулах		Гэрээт ажлын дүнгээр	“Хөдөлмөрийн а ю у л г ү й ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм” MNS 4969:2000
3. Бусад				
10	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тогтсон байршилд мод тарьж ургуулах	2 0 2 3 о н о о с жил бүр	3.0	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн
Нийт зардал			3.0	-

### 3.1.4. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Тус компанийн удирдлага нь үйл ажиллагааны чиглэл, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тухайн орон нутгийн иргэд, багийн ИНХ, холбогдох албан тушаалтан шаардлагатай тохиолдолд байгаль орчны төрийн бус байгууллагуудад дараах хуваарийн дагуу танилцуулж холбогдох санал, хүсэлтийг дараа оны төлөвлөгөөндөө тусган ажиллана.

Хүснэгт 13. БОМТ-г эрх бүхий байгууллага, олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

Оролцогч талууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан	Зохион байгуулах газар
Иргэд, хорооны ИНХ	Хэрэгжүүлсэн ажлаа тайлагнах, хэлэлцүүлэх, санал авах	Төслийн үйл ажиллагаа болон БОМТ, түүний хэрэгжилт, бусад	Жил бүрийн 10 сард	Хорооны Иргэний танхимд	Компанийн байранд
Шаардлага-тай тохиолдолд сонирхогч талууд, байгаль орчны төрийн бус байгууллага			-		
Нийслэлийн байгаль орчны газар	БОМТ-ний дараа оны тайлан, төлөвлөгөөг баттуулах	Төслийн үйл ажиллагаа-наас хүрээлэн буй орчин, ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ авах, хяналт шинжилгээний дагуу хийсэн ажлыг биелэлтийг тайлагнах	Жил бүрийн 12-р сарын 31-нээс өмнө	Байгаль орчин хариуцан мөржжилтийн нийтийн төв байгууллага	Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага
	БОМТ-ний тайлан, хэрэгжилтийг хянуулах		Жил бүрийн 11-р сарын 01-нээс өмнө		

### 3.2. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Төслийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хуваарийн дагуу жил бүр хийж үр дүнг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланд багтаана.

Эдгээр ажлуудыг байгууллагын удирдлага болон байгаль орчны ажилтан хариуцах бөгөөд байгаль орчны мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно.

Хүснэгт 14. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд		Хяналтын байршил	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Нийт зардал, мян. төг	Баримтлах стандарт
Хөрс	Хром, Cr	Хог хаягдлыг түр хадгалах цэг	Төслийн хугацаанд Жилд 1 удаа	25.0	“Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019
	Хар тугалга, Pb				
	Кадми, Cd				
	Никель, Ni				
	Цайр, Zn				
	Зэс, Cu				
	Төмөр, Fe				
Үс	pH	Хэрэглээний үс	Хаягдал үс	35.0	“Үндны үс. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018
	Ерөнхий хатуулаг				
	Хлорид ион				
	Сульфатын ион				
	Кальцийн ион				
	Магнийн ион				
	Натри ион				
	Хуурай үлдэгдэл				
Агаар	Жинлэгдэх бодис	Гадна агаар		50.0	“Хүрээлэн байгаа орчин. Үсны чанар. Ерөнхий шаардлага” MNS 4943:2015
	Органик бодис (XXX)				
	Органик бодис (N)				
	Хүхрийн давхар исэл, SO <sub>2</sub>			40.0	“Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016
	Азотын давхар исэл, NO <sub>2</sub>				
	Нийт тоос, TSP				
	Дуу чимээ				
Нийт зардал				150.0	-

### 3.3. Зөвлөмж

1. Шинээр барилга байгууламж барьж байгуулах, өргөтгөл хийх, техник технологийг шинэчлэх, түүхий эд, химийн бодис, урвалжийн нэр төрөл өөрчлөгдөх тохиолдолд байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээнд нэмэлт тодотгол хийлгэх шаардлагатайг анхааран ажиллах.

2. Төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-нд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэхэд шаардагдах зардлууд, ялангуяа удирдлага зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан төсөв, тооцоо хийлгэх зардлыг холбогдох мэргэжлийн байгууллагуудаар гаргуулан компанийн жил бүрийн төсөвт тусгуулан ажиллах.

3. Төслийн үйл ажиллагаатай холбоотой БОАЖЯ, МХЕГ, ЭХЯ зэрэг төрийн байгууллагуудаас авах холбогдох зөвшөөрөл, дүгнэлт болон бусад ААНБ-уудтай байгуулсан хог, түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулан ажиллах.

4. Журмын 4.12-т заасны дагуу тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг аймаг, нийслэлийн томилсон ажлын хэсэг газар дээр нь хянаж үнэлсэн нэгдсэн дүн 90%-аас дээш гүйцэтгэлтэй байвал төсөл хэрэгжүүлэгчээс боловсруулж ирүүлсэн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлгөөг хянан батлах нэг нөхцөл болохыг анхаарах.

5. БОМТ-ний дагуу хийгдсэн ажлуудыг тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийн тайланд дэлгэрэнгүй тусгаж өгөх тул тухайн хийж гүйцэтгэсэн ажил тус бүрт нотлох баримтуудыг бүрдүүлсэн байх нь чухал.

6. Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хянаж, батлахад БОМТ-нд тусгагдсан ажлуудыг ач холбогдоор нь дараах байдлаар үнэлдэг тул цаашдын үйл ажиллагаандaa анхаарч ажиллах нь зүйтэй.

#### Хүснэгт 15. БОМТ-ий бүрэлдэхүүн хэсгүүдийн үнэлгээ

№	Менежментийн төлөвлөгөө	Үнэлгээ	Эзлэх хувь, %
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ	Маш их	43
2	Химийн бодис болон осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	Их	31
3	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	Бага	12
4	Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө	Дунд	14
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө		
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр		

Байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Цагаан уулын оргил” ХХК

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө  
“Бизнес Плаза” 501 тоот

Утас: 7013 1114, 99184930

И-мэйл: tsagaanuuliinorgil@gmail.com

Facebook: “Цагаан уулын оргил” ХХК Байгаль орчны зөвлөх үйлчилгээ